



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

### XV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XV хурал 2020 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 13:30 цагаас Төрийн ордон дахь Монгол Улсын Шадар сайдын ажлын өрөөнд 96 хувийн ирцтэйгээр хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Улсын онцгой комиссын шуурхай штабаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;  
*Шуурхай штабын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Б.Ууганбаяр*
2. 2020 оны эхний ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулах талаар;  
*Улсын онцгой комиссын орлогч дарга, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд*
3. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн талаар;  
*Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан*
4. БНСУ-ын хөдөлмөрийн биржээс ажлын санал, цагаачалын албанаас цахим виз нь ирсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллах Монгол Улсын иргэдийн талаар;  
*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг*
5. Гамшгаас хамгаалах тухай болон Онц байдлын тухай хууль, үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан үйл ажиллагааг зохицуулах хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их хурлын гишүүн Ж.Энхбаяр нарын мэдээллийг сонсов.

#### ТАНИЛЦУУЛСАН НЬ:

1. Дорнод аймгийн Баянхошуу хилийн боомтоор газрын тосны экспортын тээвэрлэлтийг сэргээх бэлтгэл ажлыг хангасан ажлын талаар;
2. Ашигт малтмалын экспортын тээвэрлэлтийн тасралтгүй байдлыг хангах хүрээнд БНХАУ-руу тээвэрлэлт хийж буцаж ирсэн ашигт малтмалын тээврийн хэрэгслийн ээлжийн жолооч нарын талаар Оюу Толгой ХХК-аас ирсэн хүсэлтийн талаар;

3. Улсын онцгой комисст иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хандив, түүний зарцуулалтын талаар:

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

А. Шинэ коронавируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, хяналтыг сайжруулах зорилгоор гадаад улс орнуудаас ирсэн иргэдийн тусгаарлах байранд ажиглах хугацааг нийтэд нь 21 хоног болгож сунгах;

Б. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан бүх шатны төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, шуурхай удирдлага зохицуулалтын хэрэгжүүлж ажиллахын тулд Төрийн албаны тусгай шалгалт, сонгон шалгаруулалтыг өндөржүүлсэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг сахиулан тусгайлсан болон хялбаршуулсан нөхцөлөөр яаралтай зохион байгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн албаны зөвлөлд чиглэл болгох;

В. Гамшгаас хамгаалах тухай хууль болон Онц байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, түүнчлэн шинэ коронавирусын халдвартай тэмцэх үйл ажиллагааг зохицуулах тусгайлсан хуулийн төсөл боловсруулах тухай ажлын хэсгийн саналыг дэмжих нь зүйтэй гэж тус тус шийдвэрлэв.

Нэг. Зам, тээвэр хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгаланд:

1.1 Олон улсын төсөл хөтөлбөрийн шугамаар хийгдэх бүтээн байгуулалтын ажилд нэн шаардлагатай удирдлага, санхүүгийн болон инженер, техникийн мэргэжилтнүүдийг хүлээн авч, ажиллуулах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах;

Хоёр. Зам, тээвэр хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумьяабазар,

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,

Гаалийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

холбогдох аймгийн Засаг дарга нарт:

2.1. Монгол Улс - БНХАУ-ын хилийн автозамын боомтуудад уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх талаар БНХАУ-ын талтай шуурхай үр дүнтэй хэлцэл хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах;

2.2. Замын - Үүдийн хилийн боомтод вирусын халдвараас урьдчилан сэргийлэх холбогдох заавар журмыг мөрдөж ажиллах, үйл ажиллагааг эрчимжүүлэх;

2.3. "Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам"-д заасан нөхцөл шаардлагыг

хангасны үндсэн дээр хилийн Баянхошуу, Бичигт, Булган боомтуудаар гүйцэтгэх экспортын тээвэрлэлтийг яаралтай эхлүүлэх, хилийн Бургастай боомтыг нээх арга хэмжээ авах;

2.4. Хилийн хяналтын байгууллагууд экспортын тээвэрлэлтийн замын зураглал /карт/-ын судалгааг үндэслэн хилийн боомтуудын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх;

2.5. Улс хоорондын тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах хүрээнд хилийн бүсэд автотээврийн хяналтын байцаагчийг ажиллуулах;

Гурав. Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт:

3.1. БНСУ-ын талын визний зөвшөөрлийг үндэслэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллах Монгол Улсын иргэдийн эрүүл мэндийн үзлэг, цахим сургалтыг шат дараатай зохион байгуулах, холбогдох зохицуулалт, хяналтын арга хэмжээг авч ажиллах;

3.2. БНСУ-руу хөдөлмөрийн гэрээгээр явах болон ирэх Монгол Улсын иргэдийг захиалгат нислэгээр тээвэрлэх асуудлыг шийдвэрлэх, бусад зохион байгуулалтын арга хэмжээ авах;

Дөрөв. Батлан хамгаалахын сайд,  
Улсын онцгой комиссын орлогч дарга Н.Энхболдод:

4.1. Шинэ төрлийн коронавируст халдварын цар тахалтай тэмцэх эрсдлийг бууруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд Онц байдлын тухай хуулийг яаралтай шинэчлэн боловсруулах асуудлыг судалж, УИХ-ын гишүүн Ж.Энхбаярын ахалсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж ажиллах;

Тав. Улсын онцгой комиссын орлогч дарга,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
хошууч генерал Т.Бадрал:


5.1. Цаашид коронавируст халдварын тохиолдлын тоо нэмэгдэж нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд гадаад улс орноос эх орондоо ирж буй иргэдийг тусгаарлах, ажиглалтад авах хээрийн хуаранг төрийн цэргийн байгууллагуудад түшиглэн байгуулах боломж нөхцлийг судалж танилцуулах;

Зургаа. Дорнод аймгийн Засаг дарга,  
онцгой комиссын дарга М.Бадамсүрэн  
Өмнөговь аймгийн Засаг дарга,  
онцгой комиссын дарга Н.Наранбаатар нарт:

6.1. "Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам"-д дурьдсан шаардлагуудыг хангасан Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийн дагуу Дорнод аймаг дахь Баянхошуу боомтоор газрын тосны экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн, халдвараас сэргийлэх дэглэмийн дагуу явуулах;


6.2. Оюу Толгой ХХК-ний зэсийн баяжмалын экспортын тээвэрлэлтийн тасралтгүй байдлыг хангах, тухайн компаний зүгээс халдвар хамгааллын дэглэмийг баримтлан БНХАУ-руу тээвэрлэлт хийж өдөртөө буцаж ирсэн тээврийн хэрэгслийн ээлжийн жолооч нарыг 14 хоног тусгаарлахгүйгээр мэргэжлийн байгууллагын зөвлөмж, хяналтын дор үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА,  
ШАДАР САЙД



Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

 Г.АРИУНБУЯН